

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Билгээ	Дугаар	L177
Оршин суугаа аймаг	Говь-Алтай аймаг	Оршин суугаа сум	Тонхил
Төрсөн газар	Тонхил сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хүйтний хурал	Сүм хийдийн дугаар	ГАТХ 109
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 28	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Говь-Алтай аймгийн Тонхил сумын Хүйтний Хурал

Асуулт: -Хүйтний хурлын тухай ярьж өгнө үү?

Хариулт:-Дээр үед Зүйл багийн сумын төвөөс Зүйл багт 40-өөд км газар нэг Хүйтаны байшин гэж нэг байшин байсан. **Тэрэн** дээр үргэлж жижүүр манаатай, нэг лам тэндээ тахил,зулыг нь үргэлж барьж байдаг нэг лам байсан юм гэнэ лээ. Тэгээд улиралд нэг удаа энэ сумын төвийн хүрээнээс лам нар очиж уншлага хийдэг тийм юм байсан юм гэж хуучны улсууд ярьдаг юм, би сайн мэдэхгүй юм. Өөрөө тэр хурал номд нь сууж барьж байх юм биш, , хөгшчүүл тэгж ярьж байсан. Тэр байшин нь сүүлдээ нураад түүр нь л үлдсэн байна лээ.

Асуулт:-**Хүйтан** гэдэг газрыг Хүйтэн гээд андуураад биччихсэн юмуу?

Хариулт:-**Хүйтангийн** байшин гэж нутгийн ард түмэн, хуучны хөгшчүүл бүгд **Хүйтан** гэж нэрлэдэг юм байна лээ. Тэр байшин Зүйл багийн нутагт байна. Байшингийн түүр.

Асуулт:-Тэнд байнгын хурал ном хурдаг уу, олон лам байдаг уу? Зүйлийн хүрээний нэг салбар жижигхэн?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Салбар. Одоогийнхоор бол нэг багийн төв нь байсан юмуу шашны. Тиймэрхүү л юм байсан юм шиг байгаа юм. Тэгээд эзэнгүй орхидоггүй.

Асуулт:-Нэг лам байнга хараад, зул хүжийг нь өргөөд.

Хариулт:-Зул хүжийг нь өргөөд байж байдаг тийм байсан юм гэж хуучны хөгшчүүл ярьдаг юм.

Асуулт:-**Хуйтангийн** байшингийн ойролцоо тахилгатай үул овоо байна үү?

Хариулт:-**Хуйтангийн** байшингаас голоосоо зүүн тийшээ гараад жинхэнэ **Тонхил сумын** том тахидаг овоо байгаа. Сумын хэмжээнд тахиж байсан, дээр үеэсээ уламжлаад ирсэн. Одоо ч тахиж байна.

Асуулт:-Ямар нэртэй үул?

Хариулт:-Их овоо гэдэг газар бий.

Асуулт:-Тэр барилга нь чулуун байшин байсан гэл үү?

Хариулт:-Миний мэдэхийн чулуун байшин байсан, хөгшчүүл ярих нь хажууд нь шавар байшин барьсан байсан, тэгээд нэг мэдэхэд л дээрээсээ цөмрөөд доошоо уначихсан байсан. Малтаж барьж үзсэн харсан хүн байдаггүй, дотор нь янз бүрийн л юм байсан, тэр нь чухам дороо орсон юмуу, яасан юм гэж ярьдаг юм байна лээ.

Асуулт:-Чулуун байшин сүм хэлбэртэй байсан юмуу, зүгээр л нэг ийм дөрвөлжин оройтой байсан юмуу?

Хариулт:-Чулуун байшин зүгээр л нэг дөрвөлжин оройтой, одоогийн байшин шиг л янзтай юм байсан.

Асуулт:-Хэд орчим оны үед тэр байшинг барьсан юм бол, багцаа нь?

Хариулт:-Мэдэхгүй дээ. Хажууд нь тэр чулуун байшингийн хажууд шавран байшин байсан бололтой тийм туурь байсан. Гайгүй том. Тэр нь ямархуу хэлбэр дүрстэй, сүм хэлбэртэй байсан юмуу, ямар байсан юм тэрнийг нь мэдэхгүй юм, тэр нь нэлээн эртхэн нураад бариад тэгчихсэн юм байна лээ.